



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

Хөрөнгийн зах зээл

Э-СОНИН

2020

5-P CAP

"БОДЬ ДААТГАЛ"
КОМПАНИ НЭЭЛТТЭЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ
БОЛЛОО

"ТҮМЭН ШУВУУТ" ХК
КОМПОСТ БОРДООНЫ
ҮЙЛДВЭРИЙГ НЭЭЛЭЭ

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-
ИАС НОГДОЛ АШИГ
ХУВААРИЛСАН ТАЙЛАН
ИРҮҮЛЛЭЭ





Зах зээлийн тойм

/2020.05.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

21

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

4,489,921,052

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

48,375,190

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/


Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/


4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

2,278


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.05.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	Ард секьюритиз УЦК ХХК	6,084,723	1,312,836,435.62	6,299,158	1,345,549,491.19	2,658,385,926.81
2	Голомт Капитал УЦК ХХК	14,475,633	1,193,250,692.17	15,921,099	1,281,107,602.54	2,474,358,294.71
3	Монсек УЦК ХХК	846,781	619,129,093.61	769,241	620,911,180.97	1,240,040,274.58
4	Стандарт инвестмент УЦК ХХК	14,910,605	557,723,643.21	15,281,173	594,607,529.02	1,152,331,172.23
5	Мирэ Эссет Секьюритис Монгол УЦК ХХК	5,569,900	168,046,516.16	4,671,807	160,380,586.03	328,427,102.19
6	БиДиСек УЦК ХХК	1,429,896	178,047,161.53	568,345	106,568,122.51	284,615,284.04
7	Евразиа капитал монголиа УЦК ХХК	121,200	100,668,200.00	117,605	99,917,200.00	200,585,400.00
8	Гаули УЦК ХХК	186,459	42,132,617.29	1,623,784	71,108,367.10	113,240,984.39
9	Бумбат-Алтай УЦК ХХК	1,870,973	62,262,286.56	488,418	22,319,885.07	84,582,171.63
10	Ти Ди Би Капитал УЦК ХХК	495,596	40,411,799.77	301,284	30,129,069.08	70,540,868.85
11	Гүүдсек УЦК ХХК	1,223,377	56,438,928.97	41,818	6,272,789.04	62,711,718.01
12	Райнос инвестмент УЦК ХХК	0	0.00	1,868,461	57,289,858.70	57,289,858.70
13	Апекс Капитал УЦК ХХК	164,719	21,232,622.86	218,531	19,056,221.81	40,288,844.67
14	Ард капитал групп УЦК ХХК	113,784	18,569,117.64	32,919	13,326,242.90	31,895,360.54
15	Централ секьюритиз УЦК ХХК	327,898	24,232,396.04	28,888	4,800,804.00	29,033,200.04
16	Новел инвестмент УЦК ХХК	6,496	1,963,601.50	94,856	25,625,965.71	27,589,567.21
17	СИКАП УЦК ХХК	359,413	24,427,655.75	0	0.00	24,427,655.75
18	Дэлгэрхангай секьюритиз УЦК ХХК	1,324	16,100,996.00	0	0.00	16,100,996.00
19	Зэргэд УЦК ХХК	99,126	10,768,857.50	6,989	3,086,792.00	13,855,649.50
20	Санар УЦК ХХК	23,342	12,230,067.80	7,570	1,544,300.00	13,774,367.80

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.05.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	2,317,879	695,366,900	340	300	-11.76
2	APU	АПУ	395,874	213,063,808	543	520	1.22
3	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	2,234	178,092,400	80,000	65,000	28.64
4	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	115,718	170,932,158	1,519	1,380	-2.44
5	AIC	АРД ДААТГАЛ	144,623	101,426,248	720	652	-1.39
6	DAZ	ДОРНОД АВТО ЗАМ	38,809	100,127,220	2,580	2,580	0.00
7	EER	АРИГ ГАЛ	34,507	99,960,760	3,000	2,890	-6.77
8	NEH	ДАРХАН НЭХИЙ	6,560	85,282,700	13,100	13,000	-1.52
9	LEND	ЛЭНДМН ББСБ	2,307,895	80,069,335	39	30	20.08
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	15,630	79,586,514	6,250	4,200	-21.18
11	ADB	АРД КРЕДИТ ББСБ	1,065,672	79,144,869	78	70	-4.32
12	GOV	ГОВЬ	420,837	78,632,972	205	161	15.20
13	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,249,328	55,673,029	47	43	-3.58
14	MFC	МОНОС ХҮНС	690,716	45,754,551	69.9	65.1	2.70
15	GHC	ГАН ХИЙЦ	3,399	40,788,000	12,000	12,000	-4.00
16	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	813	21,914,920	31,000	23,000	29.17
17	TUM	ТҮМЭН ШУВУУТ	132,402	18,776,736	150	137	-0.07
18	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	83,154	17,012,816	221	200	-2.45
19	INV	ИНВЕСКОР ББСБ	5,927	14,828,816	2,670	2,291	0.48
20	AMT	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	64,777	13,019,825	225	198	21.10



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-04-30	2020-05-31		
1	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	2,120	225.00	290.00	65.00	28.89
2	ХӨСӨГ ТРЕЙД	2,370	2,242.00	2,578.00	336.00	14.99
3	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	1	603.88	694.00	90.12	14.92
4	ХӨВСГӨЛ УСАН ЗАМ	2	430.22	494.00	63.78	14.82
5	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	1	139.00	158.00	19.00	13.67
6	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	100	300.00	340.00	40.00	13.33
7	ТАВАН ТОЛГОЙ	6,029	4,926.00	5,580.00	654.00	13.28
8	БИ ДИ СЕК	4,733	896.00	1,013.00	117.00	13.06
9	БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ	17,320	1,450.00	1,600.00	150.00	10.34
10	БАГАНУУР	15	825.00	900.00	75.00	9.09
11	РЕМИКОН	2,901	25.00	27.00	2.00	8.00
12	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	85	31,000.00	33,000.00	2,000.00	6.45
13	УЛААНБААТАР ХИВС	212	16,000.00	17,000.00	1,000.00	6.25
14	МОНГОЛ БАЗАЛТ ХК	62,968	204.33	214.99	10.66	5.22
15	МАХИМПЕКС	3,490	2,545.00	2,650.00	105.00	4.13
16	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	28,767	508.00	528.93	20.93	4.12
17	АЙТҮҮЛС	29,600	75.00	78.00	3.00	4.00
18	НЭХЭЭСГҮЙ ЭДГЭЛ	1	2,340.00	2,400.00	60.00	2.56
19	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	29	391.10	400.00	8.90	2.28
20	СИЛК НЕТ	100,285	708.20	720.00	11.80	1.67

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-04-30	2020-05-31		
1	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	56	4,250.00	2,825.00	-1,425.00	-33.53
2	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	2,720	900.00	611.00	-289.00	-32.11
3	ТАЛХ ЧИХЭР	449	14,000.00	11,000.00	-3,000.00	-21.43
4	ДӨРВӨН-УУЛ	70	800.00	650.00	-150.00	-18.75
5	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	13,589,549	41.62	34.00	-7.62	-18.31
6	СОР	428	850.00	725.00	-125.00	-14.71
7	ТЕХНИК ИМПОРТ	14	9,345.00	8,000.00	-1,345.00	-14.39
8	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	3	79,950.00	68,650.00	-11,300.00	-14.13
9	МОНГОЛ САВХИ	75	520.00	450.00	-70.00	-13.46
10	АВТО ИМПЕКС	7	1,960.00	1,700.00	-260.00	-13.27
11	МОНГОЛ ШУУДАН	1,027,604	670.00	583.31	-86.69	-12.94
12	ЛЭНДМН ББСБ	8,935,201	36.00	31.42	-4.58	-12.72
13	ХЭРЛЭН ХИВС	100	41.40	37.00	-4.40	-10.63
14	ЦАГААНТОЛГОЙ	28	1,500.00	1,350.00	-150.00	-10.00
15	АВТО ЗАМ	24	3,290.00	3,000.00	-290.00	-8.81



"БОДЬ ДААТГАЛ" КОМПАНИ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/63 тоот тушаалаар "Бодь Даатгал" ХК-ийн нийт 235,319,718 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэж, нийт гаргасан хувьцааны 20 хувь буюу 47 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг олгосон.

Тус компани олон нийтэд арилжаалах хувьцааны 75 хүртлэх хувь буюу 35.2 сая ширхгийг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар буюу нэгжийн үнийг 113 төгрөгөөр, 25-аас доошгүй хувь буюу 11.7 сая ширхгийг захиалгын бүртгэлийн аргаар нэгжийн үнийг 113-135 төгрөгийн хооронд нийтэд санал болгон худалдаж, нийт 5.3-5.58 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх бөгөөд үүнийг хөрөнгө оруулалт, технологийн хөгжүүлэлт, сайжруулалтанд зарцуулахаар төлөвлөж байгааг үнэт цаасны танилцуулганд дурджээ.

Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг "Би Ди Сек ҮЦК" ХК, аудитын үйлчилгээг "БДО Аудит" ХХК, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг "Гэрэгэ эстимэйт" ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг "ИЭЛСИ" ХХН тус тус үзүүлж байна.

"БОДЬ ДААТГАЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГЫН НЭЭЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн "Бодь даатгал" ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр болж өнгөрлөө. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Бодь Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Г.Саруул, "Бодь Даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, "БиДиСек ҮЦК" ХХК-ийн Тэргүүн дэд захирал Д.Лхагвадорж, "Транс Банк" ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Отгонбаяр нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6232 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

"Бодь Даатгал" ХК нь МХБ-ийн үйл ажиллагаа, ашиг орлого, засаглалаараа тэргүүлэгч компанийн үнэт цаасны бүртгэлийн I-р ангилалд бүртгэгдсэн бөгөөд нийт санал болгож буй хувьцааныхаа 60 хувийг нь стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар буюу нэгжийн үнийг 113 төгрөгөөр, 20 хувийг нь олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар нэгжийн үнийг 113-135 төгрөгийн хооронд санал болгон худалдаж, нийт 5.3-5.6 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх бөгөөд татан төвлөрүүлсэн хөрөнгийг хөрөнгө оруулалт, инноваци

технологийн хөгжүүлэлт, сайжруулалтанд зарцуулахаар төлөвлөжээ.

"Бодь даатгал" ХК нь 2014 оноос Франц улсад төвтэй эрүүл мэндийн даатгалаар дэлхийд тэргүүлэгч АХА групптэй давхар даатгал, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд insurtech технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн цахим даатгалын үйлчилгээгээр салбартаа манлайлан, нөхөн төлбөрийг харилцагчийн хүссэн сошиал сувгуудаар дамжуулан хамгийн богино буюу 20 минутад багтаан шийдвэрлэж байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2020 оны 5-р сарын 25-наас 6-р сарын 08-ны өдрүүдэд 08:30-16:00 цагийн хооронд Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

"ТҮМЭН ШУВУУТ" ХК КОМПОСТ БОРДООНЫ ҮЙЛДВЭРИЙГ НЭЭЛЭЭ

2019 онд үнэт цаасаа олон нийтэд нээлттэй санал болгон гаргасан "Түмэн Шувуут" ХК нь үнэт цаасны танилцуулганд тусгасан 4 төрлийн томоохон ажлын нэг болох цэвэр байгалийн 100% компост бордооны үйлдвэрийг нээж, ашиглалтанд оруулсан байна.

Энэхүү үйлдвэр нь тахианы сангасыг дэвшилтэт технологиор боловсруулж, Монгол орны байгаль цаг уур, хөрсний онцлогт нийцсэн органик бордоо үйлдвэрлэх бөгөөд ийнхүү ногоон байгууламж, газар тариалан эрхлэгчдэд чухал хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж салбарын сайд онцолсон байна.

Үйлдвэрийн нээлтийг тохиолдуулан "Түмэн Шувуут" ХК-ийн хамт олон Нийслэлийн ногоон байгууламжид хувь нэмрээ оруулж, Нийслэлийн хот тохижилтын газарт 5 тонн "100%" Компост бордооны дээжийг хандивласан байна.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИАС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛСАН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

"Ард Кредит ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн №2020/4 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгийн 50 хувь буюу нэгж хувьцаандаа 4.23 төгрөгийг ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн боловч 2019 оны санхүүгийн тайланд аудитын залруулга хийгдсэнтэй холбогдуулан ТУЗ-ийн 2020/6 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 3.9 төгрөг хуваарилахаар болсон бөгөөд үүний дагуу нийт 1.09 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 1642 хувьцаа эзэмшигчдэд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан бүрэн тараасан байна.



"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ИЙН ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Атлантын зуны цагаар 2020 оны 6-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт (Улаанбаатарын цагаар 6-р сарын 26-нд 03:00 цаг) Канад улсын Нова Скошиа мужийн Халифакс хотод цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Цахим хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. 2019 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох;
3. Компанийн аудиторыг томилох;
4. Компанийн 2017 оны 6-р сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан "Хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөний хэлэлцээр"-ийг батлах;
5. Компанийн "Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөр"-г нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэрийг батлах эсэхийг хэлэлцэх;
6. Бусад асуудлууд

Ээлжит хуралд оролцох, санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2020 оны 5-р сарын 21-ний өдөр байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээллийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдэд үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргэх бөгөөд ээлжит хурлын талаар дэлгэрэнгүй

мэдээллийг Эрдэнэ Ресурсийн Монгол Улс дахь төлөөлөгч "Эрдэнэ Монгол" ХХК-ийн Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага Тойруу, Монруд ХХК-ийн байр хаягаар холбогдон авна уу.

Англи, монгол хэлээр мэдээлэл авах имэйл: nadya@erdene.com

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд ажиллана.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн нь 2020 оны 3 сарын 31-нд дуусгавар болсон нэгдүгээр улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн мэдээллээс гадна COVID-19 вирусний нөлөөллийн талаарх мэдээлэл ирүүлсэн байна.

2020 оны I улиралд Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүлээн авсан бөгөөд East Asia компаниар Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ хийлгэж цаашид нарийвчилсан үнэлгээг дуусгахад бэлэн болсон. Мөн Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ болон анхны инженерчлэл загвар төслийн 3 хэмжээст загварчлалыг гаргасан байна.

Компани 2020 оны 1-р сарын сүүлээс эхлэн COVID-19 вирусний тархалтаас оролцогч талуудыг хамгаалах арга хэмжээний хүрээнд томилолтын хязгаарлалт хийж, зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн дэмжлэгийг Монголын болон олон улсын ажилтнууд даа үзүүлснээр бүх оролцогч талууд, үндсэн үйл ажиллагаагаа вирусний тархалтын эрсдэлээс хамгаалсаар байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN